Төсвийн хөрөнгөөр 233,891.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Баянхонгор сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.03.31-ний өдрийн 9/56 тоот "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" тогтоолоор 94,950.0 мянган төгрөгийн бараа материал, хандиваа 9,135.0 мянган төгрөгийн бараа материал нийт 104,085.0 мянган бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Нийт 172,301.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, захирлын тоот тушаалаар 2,391.6 мянган төгрөгийн материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,231,024.6 мянган төгрөг болж 5,472,853.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5400.0 мянган төгрөгөөр машины мотор худалдан авч сайжруулалтаар бүртгэсэн, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023.02.13-ний өдрийн "Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 13/11 тоот тогтоолоор 4,286,227.3 мянган төгрөгийн хөрөнгө, Аймгийн ИТХ-ийн хуралдааны 2023.12.05-ны өдрийн "Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 17/64 тоот тогтоолоор 741,362.4 мянган төгрөгийн хөрөнгө, Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023.03.31-ний өдрийн "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд өмчлөгч тогтоох тухай" 9/56 тоот тогтоолоор 360,961.9 мянган төгрөгийн хөрөнгө, Аймгийн ИТХ-ын даргын 2023.11.13-ны өдрийн "Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" 107-р захирамжаар 35,700.0 мянган төгрөгийн хөрөнгө, Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023.08.21-ний өдрийн "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгөд өмчлөгч тогтоох тухай" 11/70 тоот тогтоолоор 128,519.0 мянган төгрөгийн

үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч орлого авсан нь үндсэн хөрөнгө нэмэгдэхэд шалтгаалсан байна.

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн газрын 2023.07.18-ны өдрийн "Хөрөнгө дахин үнэлэх тухай" А/231 тоот албан тоотор хөрөнгийн дахин үнэлгээ хийж үндсэн хөрөнгийн 2 дансны 37 нэр төрлийн 37,202.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоож бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасаагүй. 37,202.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдэх хугацаа дууссан, дансны үлдэгдэлгүй үндсэн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоож, анхны өртгөөр орлого, зарлага бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 580.8 мянган төгрөг болж 327.8 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь 580.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй холбоотой. Өмнөх оны өглөг 253.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 21,883,434.2 мянган төгрөг болж 3,649,191.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр дүн 3,694,191.9 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,179,738.5 мянган төгрөг, өөрийн орлого 5,000.0 мянган төгрөг нийт 1,184,738.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зарлагыг 1,179,738.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,179,738.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт 2023 оны 07 сард тодотгол хийж 75,227.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардлыг нэмж тодотгосон ба 70,227.8 мянган төгрөгийн зардлыг орон төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр батлагдсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1,269,966.3 мянган төгрөг, өөрийн орлого 6,789.0 мянган төгрөг нийт 1,276,755.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,248,362.7 мянган төгрөгийг зарцуулж, 8,392.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,248,362.7 мянган төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Цалин хөлс, урамшууллын зардлыг 3,646.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,718.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 133.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 537.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 56.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 191.2 мянган

төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 315.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 5.0 мянган төгрөгөөр нийт батлагдсан төсвийг нийт 6,603.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71502 Хот байгуулалт, тохижилт	1,254,966,300.00	1,248,362,677.68	6,603,622.32	99.5%
2	80101 Үндсэн үйл ажиллагаа	1,206,208,700.00	1,199,925,077.68	6,283,622.32	99.5%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	18,757,600.00	18,752,600.00	5,000.00	100.0%
4	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	30,000,000.00	29,685,000.00	315,000.00	99.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Замын сангаас автозамын халтиргаа гулгааны үед хэрэглэх зориулалтаар давс худалдан авахад 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд Велотрейд ХХК-тай гэрээ хийж кг давсыг 20,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан бөгөөд 2023.12.31-ний байдлаар кг давсны үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй бөгөөд гэрэл цахилгааны зардалд 143,035.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 2,760.0 мянган төгрөг, шатахууны зардалд 20,000.0 мянган төгрөг батлагдсанаас “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, Чандмань Баянхонгор ХХК-тай цэвэр бохир усаар хангах гэрээ, Шунхлай трейдинг ХХК-тай газрын тосны бүтээгдэхүүн зээлээр нийлүүлэх гэрээ, харилцагч байгууллагуудтай бараа ажил үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээ, ажил үйлчилгээ нийлүүлэх нийт 6 гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2023

оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,254,966.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,549.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,784.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь батлагдсан төсвийг нийт 6,603.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 92.1 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 41.6 мянган төгрөгөөр хэмнэж төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар зөрчил илрээгүй.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд замын сангаас орж ирсэн 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж аудитаар 20,285.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 20,285.5 төгрөгийн 3 зөвлөмж өгснийг 100% хэрэгжүүлж, биелэгдсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн 66 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	3	20,285.5	3	20,285.5	100%
Нийт дүн	3	20,285.5	3	20,285.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,898.3 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс зөрчил арилгах 1,898.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн, 2 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: 2 албан хаагчийн ХЧТА тэтгэмж 245.9 мянган төгрөгийн цалингийн цэстээр олгож, ниймгийн даатгалын мэдээнд мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4-дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 17 дугаар зүйлийн 17.1.1 “Ажил олгогч хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын мэдээг залруулж, зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг 2024.05.01-ны дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Илрүүлэлт: Газрын албанаас ирүүлсэн судалгаагаар 2023.12.27-ны өдрийн А/720 захирамжаар 398 м2 газар олгогдсон байхад санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт авлага" нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Газар эзэмших эрх олгогдсон газрыг 2024.05.01-ны дотор санхүүгийн тайланд бүртгэж, зөрчлийг арилган албан шаардлагыг хүргүүлэв.

3.Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн харилцахаас цэвэр бохир усны зардалд 192.1 мянган төгрөг, бараа материалын худалдан авахад 460.2 мянган төгрөг, спорт заалны гэрээний төлбөр 1,000.0 мянган төгрөг нийт 1,652.4 мянган төгрөгийн ебаримтгүй гүйлгээ, 11,816.0 мянган төгрөгийн ебаримтыг харилцагч байгууллагуудаас давхардуулан буюу илүү шивсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.3. дахь "татварын албаны шаардлагад нийцсэн цахим төлбөрийн баримт авсан байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг арилгаж, нотлох баримтын хамт 2024.05.01-ны дотор ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж²

1.Илрүүлэлт: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийхдээ санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг буруу нэгтгэн 902,021.3 мянган төгрөгөөр илүү тоолж, баталгаажуулсан байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд замын сангаас орж ирсэн 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн

Шийдвэрлэлт: Зөрчлийг арилгаж, нотлох баримтын хамт 2024.05.01-ны дотор ирүүлэх зөвлөмж хүргүүлэв

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХЧТА-с нийгмийн даатгал мэдээлж төлсөн	1	245.9			1	245.9		
Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор 902,021.3 мянган төгрөгөөр илүү тоолж, баталгаажуулсан.	1						1	0
2023.12.27ний өдрийн а/720 захирамжаар 398 м2 газар олгогдсон байхад санхүүгийн тайланд бүртгээгүй.	1				1	0		
Мөнгөн хөрөнгийн харилцахаас цэвэр бохир усны зардалд 192.1 мянган төгрөг, бараа материалын худалдан авахад 460.2 мянган төгрөг, спорт заалны гэрээний төлбөр 1,000.0 мянган төгрөг нийт 1,652.4 мянган төгрөгийн ебаримтгүй гүйлгээ, 11,816.0 мянган төгрөгийн ебаримтыг харилцагч байгууллагуудаас давхардуулан буюу илүү шивсэн байна.	1	1,652.4			1	1,652.4		
Нийт дүн	4	1,898.3			3	1,898.3		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй.	1	20,000.0				0	1	20,000.0
Дүн	1	20,000.0				0	1	20,000.0

-----oO-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 210/АОС71206/БНА-2024/
167/НА-СТА-ТШЗ/

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор Төхижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн харилцахаас цэвэр бохир усны зардалд 192,180 (нэг зуун ерэн хоёр мянга нэг зуун наян) төгрөг, бараа материалын худалдан авахад 460,200 (дөрвөн зуун жаран мянга хоёр зуу) төгрөг, спорт заалны гэрээний төлбөр 1,000,00 (нэг сая) төгрөг нийт 1,652,380 (нэг сая зургаан зуун тавин хоёр мянга гурван зуун наян) төгрөгийн И-баримтгүй гүйлгээ, 11,816,049 (арван нэгэн сая найман зуун арван зургаан мянга, дөчин есөн) төгрөгийн И-баримтыг харилцагч байгууллагуудаас давхардуулан буюу илүү шивсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалт "Төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх" Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.3. дахь "татварын албаны шаардлагад нийцсэн цахим төлбөрийн баримт авсан байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан

5040636

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын 1,652,380 (нэг сая зургаан зуун тавин хоёр мянга гурван зуун наян) төгрөгийн үнийн дүнтэй и-баримтыг нөхөн шивүүлэх, илүү шивсэн 11,816,049 (арван нэгэн сая найман зуун арван зургаан мянга, дөчин есөн) төгрөгийн И баримтын зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх⁴.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт даалгав⁵.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁶:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



⁴ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

⁵ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

⁶ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 208/А0571206/БНА-2024/
167/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын мэдээг мэдээлэхдээ хоёр албан хаагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг мэдээлж, нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн байна.

Энэ нь "17 дугаар зүйлийн 17.1.1 "Ажил олгогч хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дэх "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан хаагчдын 245,969 (хоёр зуун дөчин таван мянга есөн жаран есөн) төгрөгийн тэтгэмжийг нийгмийн даатгалын мэдээнд залруулж, зөрчлийг арилгах¹.

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

5040628

2. Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт хариуцуулав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 209/АОСТ/206/БНА-2024/
167/НА-СТА-ТШЗ/

1

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын албанаас ирүүлсэн газрын судалгаатай санхүүгийн тайланд бүртгэлтэй газруудыг тулган шалгахад засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/720 захирамжаар 398 м2 газрыг эзэмшүүлэхээр захирамж гарсан байхад санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040632

1. Засаг даргын захирамжаар эзэмшүүлэхээр олгосон газрыг санхүүгийн тайланд бүртгэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Б.НАРАНЦЭЦЭГ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно